

**ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН НУТАГТ  
ОРШИХ “ШОХОЙЦАГААН БУЛАГ” ХХК-НИЙ  
“ШАНД ХУДАГ” ГАНТИГ ЧУЛУУНЫ ОРДЫГ  
ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН  
2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/MV-017555/

2024 он

## ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл .....	3
1.2 Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын товч тодорхойлолт	6
1.3 Төслийн товч тодорхойлолт .....	9
1.3.1.Газар ашиглалт.....	9
1.3.2. Ордын уул-техникийн нөхцөл .....	10
1.3.3. Ордын нөөцийн тооцоо .....	10
1.3.4. Уурхайн ажиллах горим ба ашиглалтын хугацаа .....	10
1.3.5. Ашиглалтын системийн сонголт .....	11
1.3.6. Техник, тоног төхөөрөмж.....	12
2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	14
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	19
3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	22
3.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	22
3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох .....	23
3.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	23
3.6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	23
3.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	25
3.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	27
3.9 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	28
3.10 Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх .....	29

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Газар эзэмших гэрчилгээ .....	3
Хүснэгт 2. MV-017555 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн булангийн цэгүүд.....	4
Хүснэгт 3. Газрын эзэмших гэрчилгээний 000018706 дугаартай, Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж зориулалттай 2.0 га газрын булангийн цэгүүдийн солбицол .....	4
Хүснэгт 4. Шанд худаг гантигийн ордын нөөцийн тооцооны нэгтгэл .....	10
Хүснэгт 5.Уурхайн ажиллах горим.....	11
Хүснэгт 6. Овоолгын үндсэн хэмжээс.....	11
Хүснэгт 7. Уурхайн ашиглалтын системийн элементүүд .....	12
Хүснэгт 8.Төслийн техник тоног төхөөрөмжийн хүчин чадлын тойм үзүүлэлтүүд .....	13
Хүснэгт 9. Байгаль орчны шинжилгээ .....	15
Хүснэгт 10. Нөлөөллийн магадлан жагсаах аргын матриц .....	16
Хүснэгт 11. БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал .....	18
Хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
Хүснэгт 13. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ .....	22
Хүснэгт 14. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	23
Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	25
Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	27
Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	28

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.Төсөл хэрэгжих газрын байршил.....	4
Зураг 2.Төслийн талбай орчмын сансрын зураг.....	5
Зураг 3.Засаг захиргааны хуваарь .....	5
Зураг 4. Талбай орчмын үнэмлэхүй өндөр .....	6
Зураг 5. Талбайн гадаргын налуу буюу хэвгий .....	7
Зураг 6. Төслийн талбай ба сав газрын хил .....	8
Зураг 7.MV-017555 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн газар ашиглалт .....	9
Зураг 8. Газрын эзэмших гэрчилгээний 000018706 дугаартай 2.0 га талбайд байгуулсан кемпийн зураг.....	9
Зураг 9. Техник тоног төхөөрөмжийн сонголт.....	13
Зураг 10. Төслийн нөлөөллийн бүс .....	14

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

- Төслийн нэр: ▪ “Шанд худаг” гантиг чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл
- Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр: ▪ “Шохойцагаан булаг” ХХК  
 - Улсын бүртгэлийн дугаар: 2911001065  
 - Регистрийн дугаар: 2025833
- Төслийн товч танилцуулга, хүчин чадал: ▪ Жилд 50.0 мян.тн гантиг чулуу олборлох хүчин чадалтай
- Төслийн зорилго: ▪ Тус гантиг чулууны ордыг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.
- Төслийн үргэлжлэх хугацаа: ▪ 40 жил
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: ▪ MV-017555
- Газар эзэмших гэрчилгээний дугаар: ▪ №000018707, №000018706  
 Нийт талбайн хэмжээ: ▪ 35.49 га  
 Имайл хаяг: ▪ [nalgartushiq@gmail.com](mailto:nalgartushiq@gmail.com)  
 Утас: ▪ 976-99115636, 88116981

#### Төслийн байршил

MV-017555 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн Шанд худаг нэртэй гантиг чулууны талбай нь Монгол орны төвийн хэсэгт, Төв аймгийн Баян сумын нутагт Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 130 км, Багахангай дүүргээс урагш 21 км, Баян сумын төвөөс урд зүгт 6.5 км, төв автозамаас 1.5 км зайд байрлана.

- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L48-36
- Талбайн хэмжээ: 35.49 га

#### Хүснэгт 1. Газар эзэмших гэрчилгээ


Газрын гэрчилгээний дугаар	Газрын захирамж дугаар	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Хэмжээ
№000018707	ЗД-ын А/58 2020.03.31	4107032068	Уурхайн газар	35.49 га
№000018706	ЗД-ын А/152 2015.03.17	4107032068	Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж	2.0 га
<b>Нийт</b>				<b>37.49</b>

Хүснэгт 2. MV-017555 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн булангийн цэгүүд


Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	градус	минут	Секунд	градус	минут	секунд
1	107	35	43.47	47	12	40.71
2	107	35	43.45	47	12	23.73
3	107	36	23.46	47	12	23.73
4	107	36	23.46	47	12	11.72
5	107	35	41.46	47	12	11.72
6	107	35	41.46	47	12	41.72
7	107	35	49.47	47	12	41.73
8	107	35	49.47	47	12	40.73

Хүснэгт 3. Газрын эзэмших гэрчилгээний 000018706 дугаартай, Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж зориулалттай 2.0 га газрын булангийн цэгүүдийн солбицол


№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	107	35	31.11	47	12	17.33
2	107	35	29.58	47	12	21.97
3	107	35	35.99	47	12	22.96
4	107	35	37.28	47	12	18.17



Зураг 1.Төсөл хэрэгжих газрын байршил



Зураг 2.Төслийн талбай орчмын сансрын зураг



Зураг 3.Засаг захиргааны хуваарь


## 1.2 Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын товч тодорхойлолт

**Газарзүйн мужлал:** Төв аймгийн Баян сум нь Монгол улсын хөгжлийн бүсчлэлээр Төвийн бүсэд багтаж Монгол орны газар зүйн мужлалын хувьд Хэнтий зүүн урд салбар Мааньтын уулсын дундах толгодорхог тал хээрийн бүсэд хамаарагдана.


**Газрын гадаргуу:** Далайн түвшнээс дээш 1250 м өргөгдсөн. Физик газар зүйн хувьд Дундад халхын болон дорнод Монголын талархаг хээрийн мужийн тэгш өндөрлөгийн тойрог, Хэрлэн голын өмнөд баруун урд талын нам уулсын тойргуудад тус тус хуваагдан оршино. Газар хөдлөлийн эрчим 7 балл. Гадаргуугийн хувьд тэгшивтэр оройтой аажим налуутай, ойролцоогоор 1450 м өндөртэй намхан гүвээ, толгодорхог гадаргуу зонхилно. Энэ гадаргуу нь зүүн, зүүн хойш үргэлжлэх бол баруун тийш хотгор талархаг хэлбэршилтэй болдог. Төслийн район орчим дах өндөрлөг цэгүүдэд 1522 м Баян уул, 1660 м Хөх Шувуут уул, 1577 м Жаргалант уул байрлаж байна.

Гадаргуугийн рельефийн энэ төрөл нь өндөр уул нурууд, тэгш талархаг газруудын зааг болдог бөгөөд үндсэндээ талархаг газрын шинжийг илүү хадгалсан байдаг. Сумын нутаг дэвсгэр нь дундаж ба нам уулс, тал хээрийн жижиг толгод бүхий гүвээрхэг, долгиорхог, тэгш тал газар, тэдгээрийн хоорондох нугархаг нам хотсуудаар тодорхойлогдоно.

Монгол орны газар зүйн мужлалын хувьд “Шанд булаг” нэртэй талбай нь Хангай Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн муж, Хэнтийн захын уулсын тойрог Мааньтын уулсын дундах толгодорхог тал хээрийн бүсэд хамаарагдана. Төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1403 – 1501 метрийн үнэмлэхүй өндөрт байрласан байна. Мөн газрын гадаргын хэвгий буюу налуу төслийн талбай нь районд 0.1-10.6° (градус)-т байна.



Зураг 4. Талбай орчмын үнэмлэхүй өндөр



Зураг 5. Талбайн гадаргын налуу буюу хэвгий


**Хөрс, ургамлан бүрхэвч:** Хөрсний бүтэц нь тухайн шинж чанараас шалтгаалж тархалт, зузаан харилцан адилгүй байдаг. Төслийн талбай орчимд хүрэн бор, бор шаргал тал, нам дор газраа цайвар, өндөрлөг газартаа улаан хүрэн, хүрэвтэр өнгийн хөрс зонхилон ялгагдах ба хөрсний үеийн зузаан нь 0.05-0.2 м хааяа 0.3-0.4 м хүртэл хэлбэлзэнэ. Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын бүрхэвч сийрэг, хонхор хотгор газрууд өндөрлөгүүдийн бэл, хажуу, нам толгодууд нь өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн. Ургамлын бүрхэвчийг бүрдүүлэгч гол нэр төрөл нь таана, хялганат хазаар, шивээ монгол өвс зэрэг байна. Хааяа дорнод монголын хэв шинж бүхий алаг хялганат хиаг өвс, элсэг алаг өвс, хялганат өвс тал хээрийн хэв шинж бүхий харгана, үетэн-хиаг хялганат хиаг зэрэг ургамлуудтай. Нутаг дэвсгэрийн хэмжээнд модлог ургамал байхгүй, нам чийглэг газраар ургамлын бүрхэвч нь шигүү ургалттай.

**Цаг уур, уур амьсгал:** Бүс нутгийн цаг агаар нь эх газрын эрс тэс, хуурай уур амьсгалтай, хүйтэн өвөлтэй хуурай эх газарлаг мужид хамаарагддаг. Жилийн дундаж агаарын температурын -23.7 хэмээс +21.8 хэм ба хамгийн хүйтэн сар нь 1-р сард агаарын температур нь -31 хэмээс -35 хэм хүртэл хүйтэрдэг. Хамгийн дулаан үе 7-р сард +25хэмээс +35 хэм хүртэл халуун болдог. Жилийн аль ч улиралд баруун, баруун хойноосоо зүүн урагшаа чиглэлтэй салхи зонхилно. Салхины хурд 2.8-7.3 м/сек-ийн хэлбэлзэлтэй, хаврын улиралд 10-12 м/сек, сүүлийн жилүүдэд 20-25 м/сек хүрч шороон ба цасан шуурга шуурч салхилдаг.

**Ус зүй:** Талбайн орчим гадаргуугийн усан сүлжээ муу хөгжсөн ба байнгын устай тогтонги ус, урсгал ус гол, булаг шанд байдаггүй. Цөөн тоогоор тохиолдох хуурай сайруудаар ширүүн бороотой үед түр зуурын урсгал ус бий болдог. Бүс нутгийн хэмжээнд хуртай үед үүссэн нуур, тойром тохиолдох боловч удалгүй ширгэж хатдаг. Усны гол их үүсвэр нь хоорондоо харилцан адилгүй зайтай хэдэн гүний худгууд байдаг бөгөөд усны нөөц



ерөнхийдөө их тогтворгүй. Төслийн талбай нь ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд, Умард говийн гүвээт-Халхын сав газарт тус тус багтана.



Зураг 6. Төслийн талбай ба сав газрын хил

**Эдийн засаг, дэд бүтэц:** Энэ орд нь манай орны төвийн бүсийн дэд бүтэц сайн хөгжсөн нутаг дэвсгэрт хамрагдах ба талбайн ойр орших Мааньт сум засаг захиргааны байгууллага, эмнэлэг, сургууль, дулааны цахилгаан станц, шуудан холбоо, үүрэн телефон болон шилэн кабелийн сүлжээ зэрэг бий. Уг дүүрэгт нь хүн ам харьцангуй нягт суурьшилтай бөгөөд хүн амын дийлэнх хэсэг нь дээрх байгууламжууд болон хувийн бизнес арилжаа эрхлэхийн зэрэгцээ мал аж ахуй эрхэлдэг.

Шанд худаг төслийн талбай нь зам харилцаа маш сайтай, Улаанбаатар хотоос зүүн урагш 130 км, Багахангай дүүргээс урагш 21 км, Баян сумын төвөөс урагш 8 км-т байрлана. Эдгээр хот суурингуудтай төмөр зам, Монгол орны босоо тэнхлэгийг холбосон Улаанбаатар-Äرزэний хатуу хучилттай замаар шууд холбогдох буюу ордын талбайн баруун талаар 3-4 км алслалтай өнгөрдөг. Хамгийн ойр төмөр замын ачилт, зөөврийн өртөө нь Мааньт өртөө болно. Нэвтрэлтийн зэрэглэл сайн учир шороон замаар аль ч хэсэгт саадгүй зорчих бололцоотой.

Тус ордын баруун талаар 4 км-ээс холгүй УБ-Чойрын өндөр хүчдэлийн шугам, төмөр замын өртөө холбосон нам хүчдэлийн цахилгаан шугамууд өнгөрдөг. Төвлөрсөн цахилгаан хангамжтай Мааньт сумаас 8 км ойр зайд байрлах зэрэг нь цахилгаан хангамж сайтайг харуулна. Ордын талбайн залгаа гантиг, гантигжсан шохойн чулууны олборлолт явуулж буй талбайнууд цахилгааны шугамууд холбогдсон цахилгаан хангамжийн эх үүсвэр болгож холболт хийх бүрэн бололцоотой юм.

### 1.3 Төслийн товч тодорхойлолт

#### 1.3.1.Газар ашиглалт

“Шохойцагаан булаг ” ХХК-ний MV-017555 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд нийт 8.8 орчим га талбай нөлөөлөлд өртсөн байна. Үүнд ил уурхайн ухаш (1.05 га), хөрсний овоолго (6.76 га), гуу жалга (0.52 га), олон салаа шороон зам (0.47 га) зэрэг талбай эвдрэлд өртсөн байна.



Зураг 7. MV-017555 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн газар ашиглалт

Уурхайн тосгоныг 0.13 га талбайд байгуулсан ба төсөл хэрэгжүүлэгч нь Баян сумын нутагт 000018706 дугаартай газрын эзэмших гэрчилгээтэй Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж зориулалттай 2.0 га газрыг ашиглаж байна.



Зураг 8. Газрын эзэмших гэрчилгээний 000018706 дугаартай 2.0 га талбайд байгуулсан кемпийн зураг

### 1.3.2. Ордын уул-техникийн нөхцөл

Шанд худаг гантигийн орд нь газар зүйн байрлалын хувьд зам харилцаа, нэвтрэлт сайтай нөхцөлд 1440-1450 м-ийн аажим өгсүүр өндөртэй намхан уулс бүх гадарга эзэлдэг. Гантигийн ордыг ил уурхайн аргаар олборлоход тохиромжтой, уул-техникийн нөхцөлтэй.

### 1.3.3. Ордын нөөцийн тооцоо

Шанд худаг гантиг чулууны ордын нөөцөд тулгуурлан ашиглалтын талбайн хил хүрээний нөөц 2,012.45 мян.тн болж байна. Энэ нь төсөл захиалагч талын техникийн даалгавар болон эрэлтэд тулгуурлан жил бүр 50.0 мян.тн гантиг олборлон борлуулахаар энэхүү ТЭЗҮ-д тусгасан байна.

Ашиглалтын нийт хугацаанд 941.22 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 2,000.36 мян.тн гантиг олборлоно. Хөрс хуулалтын дундаж коэффициент 0.47 м<sup>3</sup>/тн байна.

Хүснэгт 4. Шанд худаг гантигийн ордын нөөцийн тооцооны нэгтгэл

№	Нөөцийн блокийн дугаар	Хайгуулын зүсэлтийн дугаар	Зүсэлтийн талбай, м <sup>2</sup>	Зүсэлтийн талбайн дундаж, м <sup>2</sup>	Зүсэлтийн зай, м	Нөөцийн тооцоон орохгу чулуулгийн эзлэхүүн, м <sup>3</sup>	Гантигийн эзлэхүүн, м <sup>3</sup>	Эзлэхүүн жин, м <sup>3</sup>	Ашигт малтмалын нөөц, тн
1	В-1	ХШ -1			100	2252	123398	2.77	341813
		ХШ -2	2513.01						
2	В-2	ХШ -2	2513.01	4507.3	102	5845	453896	2.77	1257291
		ХШ -3	6857.5						
3	В-3	ХШ -3	6857.5	6960.9	65	11154	441302	2.77	1222406
		ХШ -4	7064.2						
4	С-1	ХШ -1	445.86		43	1575	8011	2.77	22191
5	С-2	ХШ -1	445.86	586.7	103	3329	57099	2.77	158165
		ХШ -2	727.5						
6	С-3	ХШ -2	727.5	1285.9	102	3051	128115	2.77	354878
		ХШ -3	1941.78						
7	С-4	ХШ -3	1941.78	966.7	127	7061	115712	2.77	320521
		ХШ -4	701.84						
8	С-5	ХШ -4	1587.92		47	2646	71986	2.77	199401
9	<b>Бодитой В зэргээр</b>			<b>11468.1</b>		<b>19250</b>	<b>1018596</b>		<b>2821510</b>
10	<b>Боломжтой С зэргээр</b>			<b>2839.3</b>		<b>17662</b>	<b>380923</b>		<b>1055157</b>
11	<b>Ордын нийт нөөц</b>			<b>14307.4</b>		<b>36912</b>	<b>1399519</b>		<b>3876667</b>

Ордын хэмжээнд нийт гантигийн бодитой ба боломжтой (В+С) нөөц нь 3876667 тн, үүнээс бодитой (В) нөөц нь 2821510 тн, боломжтой (С) нөөц нь 1055157 тн бөгөөд гүн рүүгээ нөөц өсөх бүрэн боломжтой юм.

### 1.3.4. Уурхайн ажиллах горим ба ашиглалтын хугацаа

Уурхайн ажиллах горим нь төсөлд тусгагдсаны дагуу ил уурхай нь хүйтний улирал буюу 11-3 дугаар сарын хооронд ажиллахгүй. Уурхай 8 цагаар, 1 ээлжээр ажиллана. Харин тоног төхөөрөмжийн ажиллах хоногийг төлөвлөгөөт засварын хугацаанд засвар үйлчилгээнд зогсохоор тооцсон.

Олборлолт болон бутлалт, шигшилт тасралтгүй 6 сар үргэлжилнэ. Улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амарна. Харин техник тоног төхөөрөмжүүдэд үзлэг, үйлчилгээ болон урсгал засварт сард 2 өдөр зарцуулахаар ТЭЗҮ-д тусгажээ.

*Хүснэгт 5. Уурхайн ажиллах горим*

Д/д	Үзүүлэлт	Утга
1	Жилийн календарийн хоног	365
2	Жилд ажиллах хоног	210
3	Амралт. баяр ёслолын өдрүүд	6
4	Урсгал засвар хийх өдрүүд	10
5	Цаг агаарын саатал	7
6	Уурхайн жилд ажиллах бодит хоног	187
7	Ээлжийн тоо	1
8	Ээлжийн үргэлжлэх хугацаа. Цаг	8

Ашиглалтын нийт хугацаанд 941.22 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 2 000.36 мян.тн гантиг олборлоно. Хөрс хуулалтын дундаж коэффициент 0.47 м<sup>3</sup>/тн байна.

Уурхайн овоолгын байрлалыг сонгохдоо орд газрын уул-геологийн, уул-техникийн нөхцөл болон бүс нутгийн онцлог шинжийг харгалзан үзэж сонгосон. Үүнд:

**Шимт хөрсний овоолго:** Шимт хөрсний овоолго уурхайн урд байрлана. Ашиглалтын хугацаанд нийт 0.2 га орчим талбайд шимт хөрсний овоолго байршуулна.

**Хөрсний овоолго:** Уурхайн зүүн урд зүгт байрлана. Ашиглалтын хугацаанд нийт 6.9 га талбайд 931.3 мян.м<sup>3</sup> хөрсний овоолго хураагдана.

Ил уурхайд дотоод овоолго хийх боломжгүй тул уурхайгаас гарах хөрсийг гадаад овоолгод хураахаар төлөвлөсөн. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 941.22 мян.м<sup>3</sup> буюу сийрэгжсэн хэмжээгээр 1.13 сая.м<sup>3</sup> хөрсийг гадаад овоолгод хураана. Хөрсний овоолго нь ил уурхайгаас зүүн урд зүгт оршино.

Чулуулгийн тогтворжилт уурхайн нөхөн сэргээлтийн бодлогоос хамааруулж хөрсний овоолгын доголын оновчтой өндрийг 20 м, овоолгын ерөнхий налуууг 45 градус байхаар төлөвлөсөн байна.

*Хүснэгт 6. Овоолгын үндсэн хэмжээс*

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хөрс
1	Овоолгын өндөр	м	40
2	Овоолгын замын өргөн	м	10
3	Овоолгын замын налуу	промил	90
4	Овоолгын эзлэх талбай	га	3.9

**1.3.5. Ашиглалтын системийн сонголт**

Гантиг чулууны олборлолтыг өрөмдлөг тэсэлгээний тусламжтай сийрэгжүүлж экскаватор болон автосомасвалын хослолоор авто тээвэртэй ашиглалтын систем ашиглан уулын ажил явуулахаар төлөвлөсөн.

Уг төслөөр гантиг чулууг өрөмдлөг тэсэлгээгээр бутлан сийрэгжүүлж, авто тээврээр зөөж уурхайн ам нөхцөлөөр борлуулна.

**Ил уурхайн хэмжээсүүд**

Ордын ашиглалтын технологийн схем тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтэд үндэслэн ил уурхайн үндсэн параметруудийг сонгосон. Үүнд:

**Доголын өндөр:** Ил уурхайн ажлын доголын өндөр  $H_d=5.0$  м байна.

**Ажлын бус доголын өндөр:** Уурхайн ажлын доголыг ил уурхайн хүрээ хязгаарт хүрсэн үед нэгтгэн ажлын бус догол үүсгэх ба ажлын бус доголын өндөр /хаалтын догол/ нь 20 м байна. Доголыг гулсалт нуралтаас сэргийлэх үүднээс нэгтгэж буй 2 доголын хооронд 5 м-ийн өргөнтэй аюулгүйн тавцан үлдээнэ.

**Доголын хажуугийн өнцөг:** Ажлын доголын өнцгийг ил уурхайд ажиллах тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт болон чулуулгийн бат бэхэд тулгуурлан сонгосон. Гантиг олборлолтод экскаватор автосамосвал ажиллах бөгөөд ажлын доголын өнцөг нь 60 градус байна.

**Ил уурхайн ерөнхий хажуугийн өнцөг:** Уурхайн ашиглалтын технологийн элементүүд болох ажлын болон ажлын бус доголын өндөр ба доголын өнцөг, тээврийн ба аюулгүйн тавцангийн өргөн зэргийг ил уурхайн зохиомжлолоор байгуулахад уурхайн ерөнхий хажуугийн өнцөг 42-44 градус байна.

**Уурхайн замын өргөн:** Уурхайн капитал замын өргөнийг тухайн замаар явах тоног төхөөрөмжийн оврын хэмжээс эрчимжилтээс хамааруулан 11 м, уурхайн ёроол ахилтын үеийн замын өргөнийг 10 м байхаар тооцож төсөлд тусгасан.

**Ажлын талбайн өргөн:** Ажлын талбай нь тухайн догол бүрд хэрэгжүүлэх технологийн процессуудыг явуулах орон зайн нөхцөлийг хангахад зориулагдана. Тээврийн аюулгүй зай, техникийн ажиллах нөхцөл зэргийг тооцож үзэхэд ажлын талбайн оновчтой өргөн 30-40 м байна.

Хүснэгт 7. Уурхайн ашиглалтын системийн элементүүд

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Ил уурхайн ажлын доголын өндөр	м	5
2	Ил уурхайн ажлын бус доголын өндөр	м	20
3	Доголын хажуугийн өнцөг	градус	60
4	Траншейн замын өргөн	м	11
5	Траншейн дагуу налуу	‰	100
6	Доголын аюулгүйн бермийн өргөн	м	5
7	Уурхайн хажуугийн ерөнхий өнцөг	градус	44

### 1.3.6. Техник, тоног төхөөрөмж

Уурхайд ажиллах экскаваторыг сонгохдоо манай оронд өргөн хэрэглэгддэг, сэлбэг хэрэгслийн олдоц сайтай, уурхайн хөрс хуулалт болон олборлолтонд жилд 40.4 - 43.1 мян.м<sup>3</sup> уулын ажил хийхэд 1 ш тооцоонд сонгосон CAT-320C маркийн экскаватор, ордын хөрс болон гантиг тээвэрлэх ажилд 25 тн-н HOWO маркийн автосамосвал 1 ш, LiuGong Lonking-50 утгуурт ачигч 1ш, уурхайн хөрсийг автосамосвалаар тээвэрлэн овоолж бульдозерын тусламжтай хэлбэршүүлэх ба Shantui SD13 загварын бульдозер 1ш, БНХАУ-д үйлдвэрлэсэн JK358H маркийн өрмийн машин ашиглахаар төлөвлөсөн байна.

Мөргөцгөөс гантиг чулууг өрөмдлөг тэсэлгээний ажлаар урьдчилан буталсны дараа, экскаватораар уурхайн мөргөцгөөс хүдрийг олборлон тээврийн хэрэгсэлд ачин ангилан буталж, шигших төхөөрөмж рүү автосамосвалаар тээвэрлэн буулгана. Ингэж буулгасан хүдрийг ачигчаар бутлагчийн хүлээн авах бункерийг тэжээх бөгөөд бутлагдсан гантиг чулууг шигшин түр овоолго үүсгэнэ. Гантиг чулууг өрөмдлөг тэсэлгээгээр бутлан сийрэгжүүлж, автотээврээр зөөж уурхайн ам нөхцөлөөр борлуулна.



CAT-320C маркийн экскаватор



Howo маркийн автосамосвал



LiuGong lonking-50 маркийн утгуурт ачигч



Shantui SD13 загварын бульдозер

Зураг 9. Техник тоног төхөөрөмжийн сонголт

Төслийн техник, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүдийг доор тоймлон үзүүлэв.

**Хүснэгт 8. Төслийн техник тоног төхөөрөмжийн хүчин чадлын тойм үзүүлэлтүүд**

№	Техникийн нэр төрөл	Техникийн марк	Тоо хэмжээ, ш	Техникийн үзүүлэлт		
				Нэгж ажлын багтаамж, м <sup>3</sup> (тн)	Явах хамгийн их хурд, км/цаг	Жилийн бүтээлийн норм, мян.м <sup>3</sup>
1	Өрмийн машин	JK358H	1		8.7	9.4
2	Экскаватор	CAT-320C	1	1.0	5.5	234.9
3	Автосамосвал	HOWO	1	25	80	82.6
4	Утгуурт ачигч	lonking-50	1	2.1	19	41.58
5	Бульдозер	Shantui SD13	1	3.7	11	430.7
6	Зам усалгааны машин	HD72	1			


## 2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Гантиг чулуун ордыг ашиглах төслийн баримт бичигт туссан гол зорилго, техник, технологи, эдийн засгийн хүчин чадал, үндсэн болон туслах үйл ажиллагааны хамрах хүрээ, онцлогийг дээр тодорхойлсон бөгөөд үүнд үндэслэн давхцуулан зураглах арга, Магадлан жагсаах аргыг ашиглан байгаль орчны шинжилгээ хийж, гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эх үүсвэрийг тодорхойлов.

ТЭЗҮ-д тооцсноор ашиглалтын нийт хугацаанд 933.96 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 2 020.49 мян.тн гантиг олборлоно. Хөрс хуулалтын дундаж коэффициент 0.46 м<sup>3</sup>/тн байна. Иймд энэ хүрээнд олборлох үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд нөлөөлөл үүснэ.

Өмнөх хугацаанд явагдсан уул уурхайн олборлолтын үйл ажиллагаагаар нутгийн ландшафтын хэв шинж өөрчлөгдсөн.

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөллийн бүсийг урьдчилсан байдлаар тогтоохдоо БОНХСайдын А-117 тоот аргачлалд заасан нөлөөлөл буурах функцийг ашигласан болно. Нөлөөллийн эх үүсвэрүүдийн тэгш хэмт цэгээс хүчтэй нөлөөлөл 0-730 м зайд, дунд зэргийн нөлөөлөл 730-860 м зайд, бага нөлөөлөл 860-1300 м зайд тус тус үүсэх магадлалтай юм.



Зураг 10. Төслийн нөлөөллийн бүс

БОНХСайдын А-117 тоот аргачлалд заасан үзүүлэлтээр байгаль орчны шинжилгээ хийж үр дүнг дараах хүснэгт 4-д үзүүлэв.

Хүснэгт 9. Байгаль орчны шинжилгээ

№	Байгаль орчны шинжилгээ хийх асуултууд	Тийм	Үгүй
1	Газрын гадаргын хэв шинжид гарах өөрчлөлт	+	
2	Газар ашиглалтын өөрчлөлт	+	
3	Төсөл хэрэгжүүлэх зориулалтаар усны нөөцийг ашиглах эсэх	+	
4	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх эсэх	+	
5	Үл нөхөн сэргэх болон байгалийн ховор нөөц, баялгийг ашиглах эсэх	+	
6	Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа явагдах эсэх		+
7	Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг үйлдвэрлэх үйл ажиллагаа явагдах эсэх		+
8	Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд хатуу хог хаягдал гарах эсэх	+	
9	Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд шингэн хаягдал /бохир ус/ гарах эсэх	+	
<b>Орчны бохирдол</b>			
10	Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аливаа төрлийн бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгарах эсэх	+	
11	Дуу шуугианы нөлөө	+	
12	Чичиргээний нөлөө	+	
13	Дулааны нөлөө	+	
14	Цахилгаан соронзон долгионы нөлөө		+
15	Цацрагийн нөлөө		+
16	Гадаргын болон газрын доорх усанд бохирдуулагч бодис нэвчих үед усны бохирдол үүсэх эсэх	+	
<b>Эрсдэлийн үнэлгээ</b>			
17	Хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд үүсэх эрсдэл	+	
18	Байгаль орчинд үүсэх эрсдэл	+	
<b>Нийгэм-эдийн засаг</b>			
19	Төслийн хэрэгжилттэй холбоотойгоор нийгэмд тодорхой өөрчлөлт гарах эсэх	+	
20	Хүн амын амьжиргааны түвшин өөрчлөгдөх	+	
21	Бизнесийн таатай орчин бүрэлдэх	+	
22	Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх	+	
23	Шинээр ажлын байр бий болох	+	
24	Орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх	+	
25	Хөдөлмөр эрхлэлтэд өөрчлөлт гарах	+	
26	Тухайн орон нутгийн оршин суугчдын зан үйл, шашин шүтлэг зэрэгт		+
27	Тухайн орон нутгийн оршин суугчдын дасан зохицсон амьдралын хэв маягт сөргөөр нөлөөлөх	+	
28	Хөгжлийн хэтийн төлөвлөгөө, тухайн үед орон нутагт хэрэгжиж байгаа буюу хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл, бусад хүчин зүйлс байгаа эсэх		+
29	Байгаль орчны бохирдол, доройтол үүсгэж болзошгүй зам, тээврийн үйл ажиллагаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд явагдах эсэх	+	

Дээрх байгаль орчны шинжилгээний үр дүнг үндэслэн байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн эх үүсвэр болон нөлөөлөлд өртөгдөх байгаль орчин, нийгэм эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлохдоо “Магадлан жагсаах арга”-ыг ашиглав. (Хүснэгт 10) НҮБХХБ болон Байгаль орчин аялал жуулчлалын яамны хамтран хэрэгжүүлж буй Монгол улсын Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд боловсруулсан аргачлалд заасан магадлан жагсаах аргын хувилбарыг нөлөөллийн эх үүсвэр, тэдгээрт өртөгдөх байгаль, нийгэм, эдийн засгийн хам бүрдлийг тодорхойлоход ашигласан болно.



Хүснэгт 10. Нөлөөллийн магадлан жагсаах аргын матриц

Үзүүлэлт	Технологийн процесс										Гадаад тээвэрлэлт			Уурхайн суурин			Дэд бүтэц		НИЙТ
	Өрөмдлөг-тэсэлгээ			Ухаж ачих		Тээвэрлэх			Овоолго байгуулах				Ахуйн ус хэрэглээ	Ахуйн шингэн хаягдал	Ахуйн хатуу хог хаягдал	Цахилгаан дамжуулах шугам	Шатах тослох материалын агуулахаас бензин болон дизель түлш алдах		
	Тэсэлгээнээс үүсэх тоосонцор	Тэсэлгээнээс үүсэх дуу шүүгиан	Тэсэлгээнээс үүсэх доргио	Тэсэлгээ /үр дүнд үүсэх ухаш/	Ухаж ачих үед үүсэх тоосжилт	Ухаж ачих үеийн тоног төхөөрөмжийн дуу чимээ	Тээвэрлэлтээс үүсэх тоосжилт	Тээвэрлэлтээс үүсэх хийн ялгаралт	Тээврийн хэрэгслийн дуу чимээ	Тээвэрлэлтээс үүсэх зам	Овоолгоос дэгдэх тоос, тоосонцор	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт						Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс дуу чимээ	
Агаарын чанар	+	+	0	+	+	+	+	+	+	+	+	+	+	0	+	+	0	+	16
Хөрсний чанар	0	0	0	+	0	0	0	0	0	0	0	0	0	0	+	+	0	+	4
Усны чанар	0	0	0	+	0	0	0	0	0	0	0	0	0	0	+	+	0	+	4
Хөрсөн бүрхэвч	+	0	0	+	+	0	+	+	0	+	+	0	0	+	0	0	+	0	9
Ургамлан нөмрөг	+	0	0	+	+	0	+	+	0	+	+	0	0	+	0	0	+	0	9
Геологийн тогтоц	+	+	+	+	+	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	5
Газрын доорх усны нөөц, горим	0	0	0	+	0	0	0	0	0	0	0	0	0	+	0	0	0	0	2
Гадаргын усны нөөц, горим	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	-
Геоморфологийн хэв шинж	0	0	0	+	0	0	0	0	0	+	0	0	0	0	0	0	0	0	2
Биологийн олон янз байдал, зүйлийн элбэгшил, тархалт	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	0	0	0	+	+	16
Хүн амын амьжиргааны түвшин өөрчлөгдөх	+	0	х	+	+	+	+	+	+	+	+	+	+	0	0	0	+	0	13
Тухайн орон нутгийн оршин суугчдын зан үйл, шашин шүтлэг зэрэгт сөргөөр нөлөөлөх	х	х	0	х	х	х	х	х	х	х	х	х	х	0	0	0	0	0	-
Тухайн орон нутгийн оршин суугчдын дасан зохицсон амьдралын хэв маягт сөргөөр нөлөөлөх	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	0	+	+	+	0	17

Жич: (+) – нөлөөлөл үзүүлнэ, (0) нөлөөлөл үзүүлэхгүй, (х) хамааралгүй

ТЭЗҮ-д тусгаснаар тус ордыг ил уурхайн аргаар гадаад овоолго бүхий тээвэртэй ашиглалтын системээр олборлоно. Өрөмдлөг тэсэлгээ, ухаж ачих процесс, дотоод, гадаад тээвэрлэлт, овоолгууд, бутлах процесс зэргээс агаар орчинд тоосжилт үүсэх, 151 000 м<sup>2</sup> талбайн хөрс, ургамал нөлөөлөлд өртөнө. Хөрсний овоолгод хурдас чулуулаг овоолох үед болон салхины хурд ихтэй үед тоос агаарт дэгдэнэ.

Агаарын чанарт өрөмдлөг тэсэлгээ, ухаж ачих процессоос эхлээд тээвэрлэх гадаад овоолго, хүдэр бутлах, уурхайн суурин, дэд бүтэц үйл ажиллагаа хүртэл нийт 16 эх үүсвэрээс, хөрсний чанарт ухаж ачих, хог хаягдал, дэд бүтэц зэрэгтэй холбоотой 4 эх үүсвэрээс, усны чанарт мөн адил 5 эх үүсвэрээс, олборлолт, гадаад овоолго зэрэгт хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг бүрэн өртөх бөгөөд үүнтэй холбоотой 9 эх үүсвэрээс, геологийн тогтцод олборлолтын цогц үйл ажиллагаа болох ухаж ачих үйл ажиллагаатай холбоотой 5 эх үүсвэрээс, газрын доорх усны нөөц, горимд ус хэрэглээтэй холбоотой 2 эх үүсвэрээс, уурхайн ухаш, овоолго зэрэг нь орчны геоморфологийн нэгж гадаргын түвшинд өөрчлөлт оруулах бөгөөд үүнтэй холбоотой 2 нөлөөлөл, биологийн олон янз байдал дуу чимээ, чичиргээ, тоосжилт зэргээс амьдрах орчин нь хязгаарлагдах, устах зэрэг нөлөөтэй бөгөөд үүнтэй холбоотой 16 эх үүсвэр, нийгэм, эдийн засагт 13 эх үүсвэрээс тус тус нөлөөлөл үзүүлнэ.

### 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Зорилго:** Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

**Гол зорилтууд:**

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Төв аймгийн Баян сумын нутагт орших “Шохойцагаан булаг” ХХК-ний “Шанд худаг” гантиг чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн тухайн жилийн БОМТ-г БОАЖЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, мөн сайдын 2014 оны А-117 тоот тушаалаар батлагдсан үнэлгээ хийх аргачлалыг баримтлан боловсруулсан болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн XII сарын 10-ны дотор тухайн жилийн БОМТ- ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

**Хүснэгт 11. БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал**

№	Ажлын нэр	Зардал /мян.төг/
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	4800.0
2	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1500.0
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1320.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2000.0
5	Нөхөн сэргээлт, хаалтын зардал	-
6	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал	5000.0
7	Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	-
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
<b>Нийт зардал</b>		<b>14620.0</b>

**3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян,төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>АГААРЫН ЧАНАР</b>									
1	Ил уурхайгаас үүсэх тоосжилт	Зам талбайг усалж байх	Уурхайн зам	удаа	Үйл ажиллагааны хүрээнд			2024	“Агаарын тухай”, “Агаарын бохирдлын тухай төлбөрийн тухай” хууль MNS 0017-2-3-16:1998 MNS 4585:2008 Галын аюулгүй байдлын тухай:
2	Хорт хийн ялгарал Дуу чимээ шуугиан	Хорт хийн хэмжээг багасгахын тулд машин механизмын засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж байх	Төсөлд ашиглах машин механизм	удаа	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2024	
<b>ГАЗРЫН ГАДАРГА ХЭВЛИЙД</b>									
3	Газрыг үр ашиггүй, зохисгүй ашигласнаар газрын шим тэжээл буурах	Төлөвлөгөөнд тусгаагүй газар талбайд нөлөөлөл учруулахгүй байхаар уулын ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хянаж явуулах.	Төслийн талбайд	Тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2024	Газрын тухай хууль “Газрын тухай” хууль “Байгаль орчныг хамгаалах ухай” хуул: “Газрын хэвлийн тухай” хууль
4		Уурхайн орчныг тэмдэгжүүлэх, хил хязгаар тогтоох	Төслийн талбайд	Удаа	1000.0	1	1000.0	2024	
<b>Нийт</b>					<b>1000.0</b>				
<b>ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>									
5	Хөрсний бүтцэд гарсан өөрчлөлт	Хуулж авсан шимт хөрсийг технологийн дагуу хадгалах	Хуулсан шимт хөрс	Тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд			2024	Газрын тухай хууль MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” MNS 5917:2008 “Уул уурхайн
6	Хөрс хатуу, шингэн хог хаягдлаар бохирдох	Нефтийн бүтээгдэхүүн бүхий хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах, бохирдсон хөрсийг тухай бүрд нь цэвэрлэж байх	Төслийн талбайд	удаа	Үйл ажиллагааны хүрээнд			2024	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян,төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
7		Ашиглахгүй болсон шороон замыг хаах, явахыг хориглосон тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Хөрсний элэгдэл, эвдрэлийн нөлөөллийн бүс	тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2024	Үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
<b>ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УС</b>									
8	Унд ахуйн ус бохирдох	Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Гүний хулаг	удаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан			2024	Монгол Улсын стандарт (MNS 4943-2015), Дэлхийн банкны шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх шаардлагатай. Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998. “Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982 Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам Усны тухай хууль Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
9		Цэвэр ус нөөцлөх зориулалтын саванд хадгалах ба савны ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх	Унд ахуйн ус	удаа	300.0	1	300.0	2024	
10	Газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх	Газрын доорх усны хяналт шинжилгээ хийх	Усны нөөц, горимд үзүүлэх нөлөөллийн бүс	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт зардал тусгагдсан			2024		
11		Гүний худагт суурилуулсан тоолуурыг баталгаажуулах.	гүний худаг	ширхэг	Хариуцсан ажилтны ажлын үүрэг чиглэлд оруулах учир зардал тооцохгүй			2024	
12	Усны нөөцийн менежментийг сайжруулах	Ус ашиглах дүгнэлт гаргуулах	Усны нөөц, горимд үзүүлэх нөлөөллийн бүс	Удаа	Хариуцсан ажилтны ажлын үүрэг чиглэлд оруулах учир зардал тооцохгүй			2024	
13		Ус ашиглах зөвшөөрөл авах	Усны нөөц, горимд үзүүлэх нөлөөллийн бүс	удаа	Хариуцсан ажилтны ажлын үүрэг чиглэлд оруулах учир зардал тооцохгүй			2024	
14		Хаягдал усны зөвшөөрөл авах	Хаягдал ус	удаа	Хариуцсан ажилтны ажлын үүрэг чиглэлд оруулах учир зардал тооцохгүй			2024	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян,төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Нийт</b>						<b>300.0</b>			
<b>УРГАМЛАН НӨМРӨГ</b>									
15	Уурхай, тээвэрлэлт, шорооны ажлын үед ургамал устах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөх.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж мод тарих	Сумын ЗДТГ-тай ярилцаж, тохиромжтой газар	ширхэг	35.0 төг	100 ш	3500.0	2024	2021.10.04 өдрийн №58 дугаар МУ Ерөнхийлөгчийн зарилга “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн
<b>Нийт</b>							<b>3500.0</b>		
<b>АМЬТНЫ АЙМАГ</b>									
16	Уурхайн ойр орчмын газарт нутагладаг ан амьтдын амьдрах орчинд шууд бус байдлаар нөлөөлөх	Орон нутгийн амьтан хамгаалах үйл ажиллагаанд оролцох			Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		2024	"Амьтны аймгийн тухай" хууль: 6.1.7 дахь заалт: үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан хөнөөгдөхөөс сэргийлэх	
17		Уурхайн хашаанд үзлэг хийж бүрэн бүтэн байдалд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд засаж сайжруулах (мал, амьтан унаж бэртэхээс сэргийлэх зорилгоор)	Уурхайн эргэн тойронд	Удаа	Үйл ажиллагааны хүрээнд		2024		
<b>Нийт зардал:</b>							<b>4800.0</b>		

### 3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2024 онд уурхайн тэлэлт хийгдэх тул нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй.

### 3.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Хүснэгт 13. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Уул уурхайн олборлолтын улмаас нөхөн сэргээгдээгүй орхигдсон газарт нөхөн сэргээлт хийх	Сумын ЗДТГ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд тус сумын нутагт уурхайн эдэлбэр газар, орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх.	Төслийн талбай	-	5000.0	5000.0	2024 он	БОНБУ-ний тухай хууль, ЗГ 2013 оны 374-р тогтоол Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам
<b>Нийт зардал мян. төг</b>							<b>5000.0</b>

### 3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох

Төсөл хэрэгжих орчны оршин суугчдын газар эзэмших, ашиглах эрх хөндөгдөхгүй, одоогийн байгаа ахуй амьжиргаанд эдийн засгийн сөрөг нөлөө үзүүлэхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй зардал тооцох шаардлагагүй болно.

### 3.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Түүх соёлын өв илрээгүй болно. Илэрсэн тохиолдол харъяалалын бүсэд мэдээллэж шаарлагатай бүхий л арга хэмжээг хууль хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх хэрэгтэй.

### 3.6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 14. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Байгалийн аюул гамшиг</b>							
Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах	Нийт ажилчид	1	500.0	500.0	2024	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003-(сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012.05.17)
Нийт					500.0		
<b>Галын аюул</b>							
Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг	Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах;	Галын аюул эрсдэл		Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		2024	MNS 5390:2004, ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага Галын аюулгүй байдлын тухай хууль, /шинэчилсэн найруулга/ Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль MNS 5566:2005 Гал түймрээс
	Уурхайн болзошгүй үерээс хамгаалах байгууламж (суваг, шуудуу, далан хаалт) барих (www.achhold-ing.mn)	Галын аюул эрсдэл				2024	



Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
хангаагүйгээс галын аюул гарах	Галын зоонуудад үзлэг хийж шаардлагатай бол сайжруулах арга хэмжээ авах	Галын аюул эрсдэл				2024	хамгаалах, аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS4244-94 Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага
<b>Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар</b>							
Төслийн үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх	Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, хамруулах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2024	MNS 4968:2000“ХААЭА MNS 4995:2000, “ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS 5002:2000, “ХААЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага” MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага” MNS 5010:2001, “ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS 5105:2001, “ХАБ. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS ILO OSH 1:2003, “ХААЭА-н удирдлагын тогтолцооны талаарх удирдамж” Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Ослын үед ажиллах ИТА, ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, сургалт явуулах	Төслийн талбайд	1	500.0	500.0	2024	
	Болзошгүй осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлүүдээс урьдчилан сэргийлэх	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан				
	Болзошгүй аваар ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах	Төслийн талбайд	Иж бүрэн	500.0	500.0	2024	
	Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан				
<b>Нийт дүн</b>					<b>1500.0</b>		

### 3.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэнд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй. Хог хаягдлыг энгийн, ахуйн, аюултай гэх мэтээр Монгол улсын Хог хаягдлын тухай хуульд заасан бөгөөд эдгээрийг хэлбэрээр нь хатуу, шингэн, хийн гэж ангилав.

- Энгийн хог хаягдал гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг хэлнэ.
- Ахуйн хог хаягдал гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг хэлнэ.

Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан, ялгах, хог хаягдлыг дахин ашиглах	Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих	Энгийн хог хаягдлаас үүсэх нөлөөллийн бүс	удаа	100.0	5	500.0	2024	Хог хаягдлын тухай хууль; БОАЖ-ын сайдын А/433 тушаал “Ариун цэврийн тухай” хууль; БОАЖ-ын сайдын 2017 оны А/349 тушаал Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл; БОАЖ-ын сайдын 2017 оны А/368 тушаал Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал; БОАЖ-ын сайдын 2018 оны А/18 тушаал Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах; БОАЖ-ын сайдын 2018 оны А/443 тушаал
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж байх		Удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр			2024	
	Энгийн хог хаягдал үүсгэгч нь хог хаягдлын мэдээ тайланг тогтмол, заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.		удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр			2024	
Хог хаягдлаас ялгарах үнэр, амархан муудаж ялзрах бусад хүнсний хаягдал зэргээс халдварт өвчин тархах	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	Хог хаягдлын цэг	Удаа	1000.0	1	1 000.0	2024	
	Хуванцар сав, шил, лааз, дугуй, модны хаягдал, автомашины сэлбэг, төмрийн хаягдал, цаасны хаягдал гэх мэт дахин ашиглах, дахин боловсруулах боломжтой хаягдлуудыг нэг дор цуглуулж хуримтлуулах, боломжтой бол хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах	Энгийн хог хаягдал	Удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр			2024	

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах	Төслийн талбай	Иж бүрэн	Үйл ажиллагааны зардал			2024	Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага; БОАЖ-ын сайдын 2018 оны А/445 тушаал
	Хаягдал бохир усыг “Хийрэв” ХХК-ийн худалдаалж буй “Ариусан” бэлдмэлээр тогтмол ариутгаж бие засах газар луу зайлуулах	Ариун цэврийн байгууламж	удаа	500.0	1	500.0	2024	
<b>Аюултай</b> хог хаягдал болон шатах тослох материалаар хөрс, газрын доорх ус бохирдож болзошгүй	Хэрэглэсэн батарей, принтерийн хоргөх мэт ахуйн аюултай хог хаягдлыг уурхайн талбайд битүүмжлэл сайтай хадгалах	Аюултай хог хаягдал	Удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр			2024	Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар; БОАЖ-ын сайдын 2018 оны А/21 тушаал; MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
	Үйл ажиллагаанаас гарсан ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан хаягдал тос боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулан зайлуулах	Аюултай хог хаягдал	Удаа				2024	
<b>Нийт зардал мян. төг</b>						<b>2000.0</b>		

### 3.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян. төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
<b>Агаарын чанар</b>						
Агаарын чанарын хяналт, Тоос нийт -PM10, PM2.5, CO, NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> агууламж	Карьерын орчим-1цэг Гадаад зам-1цэг Уурхайн тосгон-1цэг	Жилд 2 удаа	3 цэгт 2 удаа	50,000 төг*2удаа*3цэг	300.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага MNS 6768 : 2019 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонголт хамгаалахад тавих ерөнхий шаардлага Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
<b>Хөрс</b>						
Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд, рН, чийг, ялзмаг, P <sub>2</sub> O <sub>5</sub>	Шимт хөрсний овоолго-1 цэг Карьер-1 цэг	Жилд 2 удаа	2 цэгт 2 удаа	25,000төг*2удаа*2цэг	100.0	MNS 5850 : 2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
Хөрсний хүнд металлууд (Pb, As, CN, Hg гэх мэт)	Карьер-1 цэг Засварын төв-1 цэг Эвдэрсэн талбайгаас-1 цэг	Жилд 2 удаа	3 цэгт 2 удаа	45,000 төг*2удаа*3цэг	270.0	
Хөрсний микробиологийн шинжилгээ	Тосгон-1 цэг Нүхэн жорлонгийн орчим-1 цэг	Жилд 1 удаа	2 цэгт 1 удаа	25,000 төг*1удаа*2цэг	50.0	
<b>Усны чанар</b>						
Усны ерөнхий химийн шинжилгээ.	Ундны усны эх үүсвэр /гүний худаг/	Жилд 2 удаа	1 цэгт 2 удаа	25,000 төг*2удаа*1цэг	250.0	MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. MNS6561:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус.
Хүнд металл тодорхойлох Pb, As, CN, Hg	Ундны усны эх үүсвэр /гүний худаг/	Жилд 1 удаа	1 цэгт 1 удаа	25 000 төг*1удаа	125.0	
Микробиологийн шинжилгээ /5үзүүлэлт/	Ундны усны эх үүсвэр /гүний худаг/	Жилд 1 удаа	1 цэгт 1 удаа	45 000төг*1удаа	225.0	
<b>Нийт зардал мян. төг</b>					<b>1320.0</b>	

### 3.9 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Нийт зардал, сая төгрөг	2023 он				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		I улирал	II улирал	III улирал	IV улирал		
Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх (5 жилд 1 удаа).	Гэрээний үнийн дүнгээр					БО-ны мэргэжилтэн	Газрын тухай хуулийн 58.5
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Тохиролцох					Үйл ажиллагааны менежер	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр					Үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль хамгаалах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр БОАЖЯ –нд хүргэж баталгаажуулах. /Тухайн жилийн БОМТ/	Дотоод төлөвлөлтөөр					Үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ –нд хүргэж өгөх. /БОМТ-ний биелэлтийн тайлан/	Дотоод төлөвлөлтөөр					БО-ны мэргэжилтэн	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Дотоод төлөвлөлтөөр					БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
<b>Нийт зардал мян. төг</b>		-					

### 3.10 Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх

**Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх.** Гантиг чулууны ордыг ашиглах төсөл нь Төв аймгийн Баян сумын нутагт хэрэгжих тул төслийн үйл ажиллагааны тайлан, мэдээг хамгийн их сонирхогч, оролцогч талууд нь эдгээр сумын удирдлагууд, ард иргэд, оршин суугчид болно. Тиймээс сонирхогчид болон оролцогч талуудад хүргэх мэдээллийг тэдгээрийн сонирхолд нийцсэн хэлбэрээр бэлтгэж, хэлэлцүүлэх, танилцуулах арга хэмжээг хийх шаардлагатай.

Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Шохой цагаан булаг ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн Төв аймгийн Баян сумын 3-р багийн иргэд, багийн дарга, сумын байгаль хамгаалагч	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээ хийсэн талаар (ppt) танилцуулга хийх	2024 онд төслийн үйл ажиллагаанаас үүссэн нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар болон хяналт мониторинг хийсэн тухай, орон нутагтай хамтран ажилласан тухай	Жил бүрийн 11 сард	Үйл ажиллагааны зардал	Байгууллагын БО-ны мэргэжилтэн	БОАЖЯ
<b>Нийт зардал мян. төг</b>				-		

БОМТ-ний биелэлтийн тайланг тухайн оны 11-р сарын 01-ний дотор аймгийн байгаль орчны газарт хүргүүлэх ба үүнээс өмнө хуваарийн дагуу нөлөөллийн бүсийн оршин суугчдад, сонирхогч талуудад төслийн талаар танилцуулж, тайлагнах ажиллагааг зохион байгуулсан байна.